



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар А-233/А/100

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 191.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ
нь:

1. Галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураан авч хадгалах, устгах, шилжүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /бригадын генерал Ц.Амгаланбаяр/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/, Улсын Ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс /Э.Амарбат/ нарт тус тус даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН
ЗӨВЛӨХ

М.ЭНХ-АМГАЛАН

ГАЛТ ЗЭВСЭГ, ТУСГАЙЛАН БЭЛТГЭСЭН ЗЭВСГИЙН
ЧАНАРТАЙ ЗҮЙЛИЙГ ХУРААН АВЧ ХАДГАЛАХ, УСТГАХ,
ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авах тухай шүүхийн шийтгэх тогтоолд тусгагдсан галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хураан авч хадгалах, устгах, шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шүүхийн шийтгэх тогтоолд тусгасан галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураан авч хадгалах, шилжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс хариуцан зохион байгуулна.

1.3. Галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураан авч шилжүүлсэн, устгасан талаарх тоо бүртгэлийг аймаг, нийслэлд тухайн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлж, хяналт тавина.

Хоёр. Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураан авч
хадгалах, устгах, шилжүүлэх ажлыг зохион байгуулах

2.1. Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлд /цаашид “эд зүйл” гэх/ хайч, сэрээ, сүх, хөрөө, халив (отвёртка), хүрз, өрөм, лоом, гал тогооны болон сахлын хутга, бороохой, ташуур, зэвсгийн чанартайгаар хэрэглэсэн мод, төмөр, чулуу, шил гэх мэт зүйлсийг ойлгоно.

2.2. Эд зүйлийг хураан авч хадгалах, устгах, шилжүүлэх албадлагын арга хэмжээ авагдсан шүүхийн шийтгэх тогтоолыг ахлах шийдвэр гүйцэтгэгч хүлээн авч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 185.2-т заасан ажиллагааг гүйцэтгэнэ.

2.2. Албадлагын арга хэмжээ авах шүүхийн шийтгэх тогтоолын хамт ирсэн эд зүйлийг ахлах шийдвэр гүйцэтгэгч хүлээн авсан тэмдэглэл үйлдэж, фото зургаар баримтжуулна. Тэмдэглэлд эд зүйлийн нэр, чанар байдал, онцлог шинж, тоо ширхэг, хэмжээ, сав, баглаа боодол, лац, тэмдэг зэргийг нарийвчлан тусгаж, хүлээлгэн өгсөн этгээдээр гарын үсэг зуруулна.

2.3. Эд зүйл шийтгэх тогтоолын хамт ирээгүй тохиолдолд холбогдох материалыг ирүүлсэн шүүхэд буцаан хүргүүлнэ.

2.4. Энэ журмын 2.1-д заагдсан эд зүйлийг ахлах шийдвэр гүйцэтгэгч хариуцсан тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хүлээлгэн өгч, цоожтой сав, сейфэнд хадгалуулна.

2.5. Шүүхийн шийтгэх тогтоолоор эд зүйлийг улсын орлогод шилжүүлэхээр тогтоосон тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63.2-т заасны дагуу шийдвэрлэж, энэ талаар тэмдэглэл үйлдэн хувийн хэрэгт хавсаргана.

2.6. Эд зүйлийг устгах ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг гүйцэтгэх ба 2-оос доошгүй хөндлөнгийн гэрчийг оролцуулж, шаардлага хангасан газар, байранд нийтэд аюулгүй аргаар устгаж акт, тэмдэглэл үйлдэж, гэрэл зургаар баталгаажуулна.

Гурав. Галт зэвсэг хураан авах

3.1. Галт зэвсэг хураан авч хадгалах, устгах шилжүүлэхээр шийдвэрлэсэн шийтгэх тогтоолыг ахлах шийдвэр гүйцэтгэгч хүлээн авсан даруй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн даргад танилцуулан Ажлын хэсэг томилуулж, шийдвэрлүүлнэ.

3.2. Ажлын хэсэг нь галт зэвсэг хураан авах үйл ажиллагааны явцыг тэмдэглэл, гэрэл зургаар баталгаажуулах ба хураан авах ажиллагааны үед галт зэвсэгтэй харьцах аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална.

3.3. Энэ журмын 3.2-т заасан галт зэвсгийн төрөл загвар, гол төмөр эсхүл сангийн анги, замгийн дугаар, үйлдвэрлэсэн он, сери, дугаар, шинж, чанар байдлын талаар тусгана.

Дөрөв: Галт зэвсгийг хадгалах

4.1. Хураан авсан галт зэвсгийг шийдвэрлэх хүртэл бууны хоолойд сум байгаа эсэхийг шалгаж, замгийг салган, гал хамгаалагчийг түгжиж, сумнаас тусад нь ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хяналтад төмөр сейфэнд хадгална.

Тав. Галт зэвсгийг худалдах, шилжүүлэх, устгах

5.1. Галт зэвсгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63.3-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч хувийн хэрэгт хавсаргана.

5.2. Устгах галт зэвсгийг цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, энэ талаар тэмдэглэл үйлдэж, хувийн хэрэгт хавсаргана.

Зургаа. Бусад

6.1. Галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураан авах, хадгалах, шилжүүлэхэд гарах зардлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 299.5-д заасны дагуу улсын төсвөөс санхүүжүүлнэ.

6.2. Галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг үрэгдүүлсэн, бусдад шилжүүлсэн бол гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oo0oo---